



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/20

Чойр

Л.Ганбаатарт тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны А/36 дугаар тушаалаар батлагдсан “Аймгийн Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ын 11.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижүүр Лханямын Ганбаатар нь ходоод, дээрх гэдэсний шархлаат үрэвсэлт өвчний улмаас Улсын төрөлжсөн мэргэжлийн эмнэлэгт оношилгоо шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай болсон тул 500 000 /Таван зуун мянга/ төгрөгийн тусламж олгосугай.

2. Л.Ганбаатарт олгох тусламжийн зардлыг байгууллагын төсвийн нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас олгохыг нягтлан бодогч /Б.Гүнжидмаа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.СОДНОМ